



**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**



**МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН  
НЭГДСЭН ХОЛБОО**

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ,  
“МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО”  
ТӨРИЙН БУС байГУУЛЛАГА ХООРОНД БАЙГУУЛСАН  
“БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫГ ДАВТАН СУРГАХ, МЭРГЭЖИЛ  
ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ АЖЛЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ”- ЧИГ ҮҮРГИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН  
ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Улаанбаатар хот  
2020 он

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫГ ДАВТАН СУРГАХ,  
МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ АЖЛЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

2020 оны 02 дугаар  
сарын 06 ны өдөр  
хот

Дугаар: 2020/31

Улаанбаатар

**Нэг. Үндэслэл**

1.1. “Барилгын тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалт, 34.2 дахь хэсэг 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.7 дахь хэсэг, “Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай” Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 21 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор нэг талаас Барилга, хот байгуулалтын яам /цаашид “яам” гэх/, нөгөө талаас түншлэгч төрийн бус байгууллага /11/ болон “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ыг төлөөлж “Монголын Барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллага /цаашид “МБНХ” гэх/ харилцан тохиролцож “Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах” чиг үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр энэхүү гэрээг 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдөр байгуулав.

1.2. Гэрээний хугацаа 3 /гурван/ жил байна.

**Хоёр. Барилга, хот байгуулалтын яамны хүлээх эрх, үүрэг**

2.1. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулахтай холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэхэд зохион байгуулагч Монголын Барилгачдын нэгдсэн холбооны оролцоог хангаж, хамтран ажиллана.

2.2. Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт заасан барилгын салбарын ажилтны мэдээллийн санг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай хамтран ашиглах, хамтран ажиллах боломжоор хангаж өгнө.

2.3. Сургалтын анги танхим, техник хэрэгсэл, Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн ажлын албаны өрөөг шинэчлэх, түрээслүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хангах талаар “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай хамтран шийдвэрлэнэ.

2.4. МБНХ-ноос хүргүүлсэн сургалтын багц цагийн шаардлагыг хангасан мэргэжилтнүүдийн холбогдох материалыг үндэслэн Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 155 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн дүрэм”-ийн 3.4-т заасны дагуу мэргэшлийн зэргийн шалгалтыг хамтран зохион байгуулах болон зориулалтын анги танхим тоног төхөөрөмжөөр хангаж хамтран ажиллана.

2.5. Хууль тогтоомж, тушаал, шийдвэрийн хэрэгжилт болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд хагас, бүтэн жилээр хяналт тавьж ажиллана.

2.6. Энэ гэрээний 2.5-д заасан ажлын санал, дүгнэлтийг Барилга, хот байгуулалтын сайдад танилцуулсаны үндсэн дээр гэрээг сунгах эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

2.7. Энэ гэрээний 4.2-т заасны дагуу гэрээг цуцлах асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

### **Гурав. Монголын Барилгачдын нэгдсэн холбооны эрх, үүрэг**

3.1. Энэхүү гэрээнд заасан Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах зэрэг ажлыг зохион байгуулах чиг үүргээ гүйцэтгэхдээ төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг удирдлага болгоно.

3.2. Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн акт Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 155 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн дүрэм, Барилга, Хот байгуулалтын сайдын 2017 оны 209 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрмийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” зэрэг баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

3.3. Энэ гэрээний нэгдүгээр хавсралтаар баталсан сургалтын жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хоёрдугаар хавсралтаар баталсан жилийн төсвийн дагуу үйл ажиллагаагаа санхүүжүүлж ажиллана.

3.4. “Барилгын салбарын ажилтны давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын чанар, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг боловсронгуй болгох, оновчтой зохион байгуулах санал, санаачилга гаргаж, эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлэх, бусад шаардлагатай асуудлаар яаманд санал тавьж шийдвэрлүүлнэ.

3.5. Сургалт зохион байгуулах зардал буюу мэргэжил дээшлүүлэх сургалтын төлбөрийн жишиг хэмжээг “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл” /цаашид “Зөвлөл” гэх/-өөр батлуулна. Сургалтын төлбөрт элсэгчийг бүртгэх, сургалтыг зохион байгуулах, шалгалт авах /мэргэшлийн зэрэг олгох мөн адил хамаарна/, дүгнэхтэй холбоотой зардал багтана.

3.6. Сургалт зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ сургалт эрхлэх чиг үүрэг хүлээсэн түншлэгч байгууллагуудын мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг нэгтгэн төлөвлөж хэрэгжүүлэх ажлыг нь мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж зохион байгуулна.

3.7. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”-ийн 3.5-д заасан дараах чиг үүргийг хариуцан гүйцэтгэнэ:

3.7.1 мэргэжил дээшлүүлэх сургалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.7.2. зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах;

3.7.3. заавал суралцах багц цагийн сургалтын агуулга, тухайн жилийн сургалтын нэгдсэн төлөвлөгөө /заавал болон сонгон суралцах багц цагийн/, шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний төслийг боловсруулж Зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах;

3.7.4. сургалтын хөтөлбөрийг Зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах;

3.7.5. сургалтын хөтөлбөр, агуулгатай уялдуулан мэргэжил дээшлүүлэх сургалтын төлбөрийн жишиг хэмжээг тогтоох саналыг Зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.7.6. мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтын сэдэв, асуулт, бодлого, загварчлал, даалгаврыг боловсруулах тестийн нэгдсэн санг тогтмол шинэчлэх, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

3.7.7. тестийн нэгдсэн сан, реферат бичих заавар, рефератын сэдэв, зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн орчин цагийн дэвшилтэт технологийн болон тусгайлсан рефератын сэдэв болон шалгалтын комиссын бүрэлдэхүүний талаар санал боловсруулж зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах;

3.7.8. их, дээд сургуулийг барилгын салбарын шинэ мэргэжлийн чиглэлээр төгссөн мэргэжилтний зэрэг горилох хүрээг нэмэгдүүлэх асуудлаар санал боловсруулан Зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

3.7.9. сургалт эрхлэгч байгууллагын сургалтын явцтай танилцах, үйл ажиллагаанд хяналт тавих, сургалтын тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.7.10. мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтад орох хүсэлт гаргасан мэргэжилтний материалыг хүлээн авч, шалгалтыг зохион байгуулах, шалгалтын дүнг Зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулах;

3.7.11. мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан болон мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтний талаарх нэгдсэн мэдээллийн санг хөтөлж, мэдээлэл, лавлагаагаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үйлчлэх;

3.7.12. мэргэшсэн болон зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн нь зэрэгтэй мэргэжилтний сургалтаар болон бие даасан хэлбэрээр багц цаг бүрдүүлсэн тухай мэдээлэл, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор хүлээн авч, нэгдсэн бүртгэлийг хөтөлж, Зөвлөлд танилцуулах;

3.7.13. холбогдох тайлан, мэдээг боловсруулж Зөвлөлд хүргүүлэх, сургалт, шалгалтын материалаар архивын нэгж үүсгэн хадгалах;

3.7.14. мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж Зөвлөлд хүргүүлэх;

3.7.15. “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”-ийн 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу мэргэшлийн зэргийн гэрчилгээ, тэмдэг олгох;

3.7.16. МБНХ нь энэ гэрээнд заасан чиг үүргийг гүйцэтгэхтэй холбогдох мэдээ, тайланг шаардлагатай тохиолдол бүрт болон улирал, хагас, бүтэн жилээр яаманд ирүүлж ажиллана.

#### **Дөрөв. Гэрээний хариуцлага**

4.1. МБНХ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад бусад этгээдэд хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцан барагдуулна.

4.2. Дараах нөхцөлийн аль нэг нь бий болсон тохиолдолд яамны санаачилгаар гэрээг цуцалж, үүний улмаас хохирол учирсан бол хохирлыг МБНХ үл маргах журмаар хариуцан барагдуулна:

4.2.1. гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас бусад шалтгаанаар төлөвлөгөөт сургалтыг зохион байгуулаагүй;

4.2.2. сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу бус, түүнчлэн холбогдох бусад шаардлагыг зөрчиж зохион байгуулсан, эсхүл сургалтыг зохион байгуулах хүний нөөц, санхүүгийн чадамжгүй нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;

4.2.3. сургалтын үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл үүсгэсэн нь МБНХ-ийн үйл ажиллагаанаас хамааралтай бол;

4.2.4. энэ гэрээг байгуулах үед зөвлөх инженерийн хугацаагүй эрхтэй, зөвлөх болон мэргэшсэн инженер, тэргүүлэх болон мэргэшсэн төсөвчдийг аттестатчилах, хуульд зааснаас бусад үндэслэлээр мэргэшлийн зэргийг цуцалсан бол;

4.2.5. барилгын салбарын түншлэгч 12 байгууллага нь бүрэлдэхүүнээс гарч сургалтын зохион байгуулалтын чадамжгүй болсон тохиолдолд;

4.2.6. хуульд тусгайлан заасан бусад нөхцөл.

4.3. Гэрээтэй холбоотой асуудлаа маргаан үүссэн тохиолдолд хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцон шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **Тав. Бусад зүйл**

5.1. Гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

5.2. Энэ гэрээний нэгдүгээр хавсралтаар баталсан “Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” болон хоёрдугаар хавсралтаар баталсан чиг үүргийг гүйцэтгүүлэх уг ажлын төсөв нь гэрээний салшгүй хэсэг байна.

5.3. Гэрээний хугацаа дуусахтай зэрэгцэн гэрээг цуцлах санал гараагүй нөхцөлд талууд энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гэрээний хугацааг сунгах, шинээр гэрээ байгуулах хүртэл хэвээр хэрэгжүүлнэ.

5.4. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол талууд саналаа бичгээр гаргана. Энэ гэрээний 1.2-т заасан хугацааг сунгах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд саналаа нөгөө талд 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

5.5. Энэ гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд яам 2, МБНХ 1 хувийг тус тус хадгална.

5.6. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон, Барилга, хот байгуулалтын сайдын тушаал, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр гэрээ байгуулах үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөн нөхцөлд гэрээг дуусгавар болсонд тооцно.

5.7. Гэрээтэй холбоотой асуудлаар маргаан үүссэн тохиолдолд хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцон шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### Гэрээ байгуулсан

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

  
..... С.МАГНАЙСҮРЭН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ  
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

  
..... Д.БАЯРСАЙХАН

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Барилгачдын талбай-3  
Засгийн Газрын байрны XII байр  
E-mail: info@mcud.gov.mn  
Web: www.mcud.gov.mn

“МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН НЭГДСЭН  
ХОЛБОО” ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

  
..... М.БАТБААТАР

“МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН НЭГДСЭН  
ХОЛБОО” ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
..... Г.ШООВДОР

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, 3-р хороо,  
Урт цагаан IV корпус, II давхар  
Утас: 314516  
mongolian.builders.federation@gmail.com  
Web: www.buildersasso.mn



Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх 2020 оны 02 дугаар сарын 04-ны 2020/02/31 дугаар гэрээний 1 дүгээр хавсралт

**БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫГ ДАВТАН СУРГАХ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГ ҮҮРГИЙГ 2020-2023 ОНД ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/Д	Салбарын хэмжээний зорилт болон үйл ажиллагааны чиглэл /Бодлогын баримт бичиг, гэрээний заалт/	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, чанар шалгуур үзүүлэлт, тоо хэмжээ	Хугацаа	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилтийг хариуцах албан тушаалтан
1	2	3	4	5	6	7
	<b>Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого</b>					
	Үйл ажиллагааны чиглэл 6.3: Барилгын салбарын инженер техникийн мэргэжилтнүүдийн мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх сургалтын болон үнэлгээний тогтолцоог боловсруулах болгох.					
	Гэрээний 3.1: Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах зэрэг ажлыг зохион байгуулах чиг үүргээ гүйцэтгэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг удирдлага болгоно.					
<b>Нэг. Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт болон мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр:</b>						
1.	1.1. Барилгын тухай хууль тогтоомж, БХБ-ын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын салбарын ажилтны даван сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм", 2017 оны 155 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, чанар шалгуур үзүүлэлт, тоо хэмжээ	Гэрээг 2020.02.15-ны дотор	2019 онд 1 жилээр байгуулсан.	2020-2023 онд 3 жилээр	БХБЯ МБНХ
	1.1.1. МБНХолбоотой байгуулсан гэрээний үүргийн биелэлт, цаашид авч хэрэгжүүлэх ажлын саналтай танилцаад яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, БХБ-ын сайдад танилцуулснаар гэрээг үргэлжүүлэн байгуулах эсэх талаар шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах. <b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b> - Гэрээний хэрэгжилт хангалттай байх; - Холбогдох хууль тогтоомжийн дагуу; - Суралцагчид, түншлэгч байгууллагуудын санал гомдол. <b>Тоо хэмжээ:</b> Гэрээ -1, төлөвлөгөө-3, төсөв -3					

	<p>салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тоны бус зөвлөл"-ийн дүрэм, 2017 оны 209 дүгээр тушаалаар батлагдсан "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрмийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" зэрэг баримт бичгүүдийг ажиллагаандаа мөрдөж ажиллах /Гэрээний 3.2/</p>	<p>1.1.2. БХБЯ-тай байгуулсан гэрээний хүрээнд:  а) 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гаргаж БСАМДМЗООТБЗөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах;  б). Зэрэг олгохтой холбоотой болон бусад асуудлаар БСАМДМЗООТБЗ-ийн хурлыг зохион байгуулах;  в). 2020 онд зохион байгуулах мэргэшсэн зэрэг горилгох, сунгах шалгалтын хуваарийг гаргаж, БСАМДМЗООТБЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулах;  г). Чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг улирал, жилээр гаргаж хэрэгжилтийг хангуулж ажиллах.  <b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b>  - Холбогдох хууль тогтоомжийн дагуу байх;  - Сургалтын төлөвлөгөө ИТА-ын мэдлэг чадварыг дээшлүүлэн шинэ түвшинд гаргахад чиглэсэн байх;  - Хурлын дэгийг баримталсан байх;  - Хурлын шийдвэр шударга, тэгш, нээлттэй байдлыг хангасан байх.  <b>Тоо хэмжээ:</b> БСАМДМЗООТБЗ-ийн хурал 9-11 удаа</p>	<p>2020-2023 онд тухай бүр</p>	<p>2019 онд Зөвлөлийн хуралдаан 3 удаа болсон.</p>	<p>Зөвлөлийн хурлыг 9-11 удаа зохион байгуулна.</p>	<p>1. МБНХолбоо  2. БСАМДМЗООТБЗ-ийн Ажлын алба  М.Батбаатар  А.Лхамсэржид</p>
<p>2.</p>	<p>1.2. Барилгын салбарын ажилтны давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу мэргэшлийн зэрэг шинээр олгох, сунгах сургалтыг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалт, зохион байгуулалт /менеджмент/-аар хангаж ажиллах.</p>	<p>1.2.1. Сургалт эрхлэгч ТББ, мэргэжлийн байгууллагуудтай түншлэлийн гэрээг байгуулж, үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж ажиллах.  <b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b>  - Гэрээний хэрэгжилт хангалттай байх;  - Холбогдох хууль тогтоомжийн дагуу,  - Суралцагчид, түншлэгч байгууллагуудын санал гомдол.  <b>Тоо хэмжээ:</b> ТББ 11 болон мэргэжлийн 1, нийт 12 байгуулага.</p>	<p>2020-2023 онд жил бүр</p>	<p>15 заалт бүхий гэрээний үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.</p>	<p>Түншлэлийн гэрээг жил бүр байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</p>	<p>1.МБНХ-ны  М.Батбаатар  Г.Шоовдор  Д.Баасанжав  Ж.Оюунчимэг    2.Сургалт эрхлэгч түншлэгч ТББ, мэргэжлийн байгууллагууд</p>



	<p>1.2.2. Сургалтын чиг үүргийг хэрэгжүүлэх түншлэгч ТББ, мэргэжлийн байгууллагуудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний саналыг нэгтгэж батлуулах, зохион байгуулагдсан сургалт бүрийн тайланг хагас, бүтэн жилээр нэгтэн, БХБЯаманд танилцуулах.</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө нь ИТА-ны мэдлэг чадварыг дээшлүүлж, олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн байх;</li> <li>- Холбогдох хууль тогтоомжийн дагуу;</li> <li>- Суралцагчид, түншлэгч байгууллагуудын санал гомдол.</li> </ul> <p><b>Тоо хэмжээ:</b> Тайлан II, IV улиралд; Зохион байгуулагч болон сургалт эрхлэгч 12 байгууллагуудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө</p> <p>1.2.3. "Монгслын Барилгачдын нэгдсэн холбоо"-ны болон БСАМДМЗООТБЗ-ийн Ажлын алба, сургалт зохион байгуулах мэргэжлийн холбоодын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, техник хэрэгсэлийн хангамжийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Мэргэшлгийн зэрэг олгох, сунгах болон бусад холбогдох төрийн чиг үүргийг хүний нөөц, техник хэрэгсэлийн хувьд хэрэгжүүлэх бүрэн чадамжтай байх.</li> <li>- Ажилтнуудаа холбогдох сургалтад хамруулж, мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн байх.</li> </ul> <p><b>Тоо хэмжээ:</b> Сургалт, ажилтнуудын тоо.</p>	<p>2020-2023 оны тайланг жил бүр</p>	<p>54 хүрээгээр 156 удаагийн сургалт зохион байгуулсан.</p>	<p>Жилд 54 ба түүнээс дээш хүрээгээр 262 удаагийн сургалт зохион байгуулна.</p>	<p>1. Зохион байгуулагч МБНХХолбоо; 2. БСАМДМЗООТБЗ-ийн ажлын алба М.Батбаатар Г.Шоовдор Б.Болормаа Д.Баасанжав</p> <p>1. МБНХХолбоо; 2. ТББ, Мэргэжлийн байгууллага</p>
	<p>1.2.3. "Монгслын Барилгачдын нэгдсэн холбоо"-ны болон БСАМДМЗООТБЗ-ийн Ажлын алба, сургалт зохион байгуулах мэргэжлийн холбоодын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, техник хэрэгсэлийн хангамжийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Мэргэшлгийн зэрэг олгох, сунгах болон бусад холбогдох төрийн чиг үүргийг хүний нөөц, техник хэрэгсэлийн хувьд хэрэгжүүлэх бүрэн чадамжтай байх.</li> <li>- Ажилтнуудаа холбогдох сургалтад хамруулж, мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн байх.</li> </ul> <p><b>Тоо хэмжээ:</b> Сургалт, ажилтнуудын тоо.</p>	<p>Жилдээ</p>	<p>Тухай бүр мэдлэг эзэмшүүлэх сургалтад хамрагдсан.</p>	<p>Холбоо, Ажлын алба, мэргэжлийн холбоод хүний нөөц, техник хэрэгсэлийн хувьд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн чадамжтай болсон байна. Удирдлага, ажилтнууд мэргэжлийн болон ёс зүйн чадамжтай байна.</p>	<p>1. МБНХХолбоо; 2. ТББ, Мэргэжлийн байгууллага</p>

3.	<p>1.2.4. Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтын сэдэв, асуулт, бодлого, загварчлал, даалгаврыг боловсруулах төстийн нэгдсэн санг тогтмол шинэчлэх, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна: /Гэрээ 3.7.6/</p> <p>а) Мэргэшлийн зэрэг горилох шалгалтын асуулт, бодлого, загварчлал, даалгаврыг боловсруулах; /Мэргэшсэн инженер горилох төстийн 50 асуултыг сонгох, зөвлөх, тэргүүлэх горилох төстийн 10 асуулт;/</p> <p>б) Мэргэшлийн зэрэг горилох мэргэжилтнүүдийн шалгалтын асуулт, бодлого, загварчлал, даалгаврыг боловсруулах /2 шат/;</p> <p>в) Мэргэжлийн ур чадварын шалгалтыг авах;</p> <p>г) Зөвлөх, тэргүүлэх 2 шатны даалгавар бэлтгэх, сонгох ажлыг зохион байгуулах.</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b> Шалгалтын сэдэв, асуулт, бодлого, загварчлал, даалгавар ИТА-ыг олон улсын түвшинд ажиллах чадамжтай болгоход чиглэсэн байх.</p> <p><b>Тоо хэмжээ:</b> 50, 2.</p>	Шалгалтын батлагдсан хуваарийн дагуу		БСАМДМЗООБЗ-ийн Ажлын алба Г.Шоовдор Д.Баасанжав Шалгалтын комисс
	<p>1.2.5. Төстийн нэгдсэн сан, реферат бичих заавар, рефератын сэдэв, зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг хүлээн авч, дэвшилтэт технологийн болон тусгайлан рефератын сэдэв, шалгалтын комиссын бүрэлдэхүүний талаар санал боловсруулж, Зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах.</p> <p>/Гэрээ 3.7.7/</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төстийн нэгдсэн сан, реферат бичих заавар, рефератын сэдэв нь дэвшилтэт техник технологийг салбарт нэвтрүүлэхэд чиглэсэн байх;</li> <li>- Шалгалтын комисс нь мэргэжлийн өндөр ур чадвартай эрдэмтэн багш нар, инженерүүдээс бүрдсэн байх;</li> <li>- Шийдвэр хууль тогтоомжийн дагуу байх.</li> </ul> <p><b>Тоо хэмжээ:</b> 2</p>	Тухай бүр	2	БСАМДМЗООБЗ-ийн ажлын алба Г.Шоовдор Д.Баасанжав

4.	<p>1.2.6. Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтанд орох хүсэлт гаргасан мэргэжилтний материалыг хүлээн авч, шалгалтыг зохион байгуулах, шалгалтын дүнг Зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулна:</p> <p>Гэрээний 3.7.10/</p> <p>а) Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд орох салбарын зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтнүүдийн мэдээллийг шинэчлэх, сонгох, санал танилцуулж, батлуулах;</p> <p>б) Шалгалтын комиссын үнэлгээний дагуу дүнг нэгтгэж, тушаал шийдвэр гаргуулах;</p> <p>в) Шалгалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;</p> <p>г) Шалгалтын дүнг шалгалт зохион байгуулагч байгууллагын вэб сайтад байршуулах;</p> <p>д) Шалгалттай холбоотой маргаантай асуудал, гомдол саналыг бичгээр хүлээн авч, шийдвэрлүүлэх.</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүсэлт гаргасан мэргэжилтний мэргэшлийн ур чадвар нь холбогдох хууль тогтоомж, дүрэмд тавигдсан шаардлагыг хангасан байх;</li> <li>- Шалгалтын комисс нь мэргэшлийн өндөр ур чадвартай эрдэмтэн багш нар, инженерүүдээс бүрдсэн байх;</li> <li>- Шийдвэр хууль тогтоомжийн дагуу байх.</li> </ul> <p><b>Тоо хэмжээ: 3</b></p>	<p>2020-2023</p> <p>2020 оны I улиралд 1 удаа; II улиралд 1 удаа; IV улиралд 1 удаа;</p>	<p>Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтыг удаа зохион байгуулж, 1168 хүн хамрагдаж, 1195 хүн тэнцсэн.</p>	<p>Мэргэшлийн зэрэг олгох, сунгах шалгалтыг жилд 3 ба түүнээс дээш удаа зохион байгуулсан байна.</p> <p>ИТА-ын мэргэшлийн ур чадвар дээшилсэн байна.</p>	<p>БСАМДМЗООБЭЗ-ийн Ажлын алба А.Лхамсэржид Ж.Оюунчимэг Б.Болормаа Г.Шоовдор Д.Баасанжав</p>
----	--	--	---	--	--

<p>5. 1.3. Инженер, техникийн мэргэжилтнүүдийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоо, хөтөлбөрийг шинэчлэн хөгжингүй орны түвшинд хүргэх чиглэлээр ажиллах.</p> <p>Лөрөөс барилгын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө - 6.3.1.7</p>	<p>1.3.1. Түншлэлийн байгууллагуудтай "Барилгын салбарын ажилтны давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын чанар, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг боловсронгуй болгох, оновчтой зохион байгуулах санал, санаачилга гаргаж эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлэх, бусад шаардлагатай асуудлаар яаманд, зөвлөлд санал тавьж шийдвэрлүүлэх. /Гэрээ 3.4, 3.7.14/</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b> Хэрэгжих боломжтой бөгөөд холбогдох хууль тогтоомжид нийцсэн, үндэсний хөтөлбөрт хүний нөөцийн чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд болон сургалтын хөтөлбөрийг хөгжингүй орны түвшинд хүргэхэд чиглэсэн байх.</p> <p><b>Тоо хэмжээ:</b> Саналууд</p>	<p>Саналыг 2020.04.15-ны дотор, 11.01-ний дотор шийдвэрлүүлсэн байна.</p>	<p>Барилга байгууламж, ашиглалтын хүрээг салгаж МНААҮХ-г түншлэлээр оролцуулж сургалт зохион байгуулсан. МБНХолбоо болон түншлэгч ТББ-уудын хооронд зар сурталчилгаа явуулах, өзб хуудсанд холбоос үүсгэн мэдээлэл солилцох болсноор хамтын ажиллагаа идэвхжсэн.</p>	<p>Барилгын салбарын ажилтны давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох талаар тодорхой санал гаргаж, яаманд танилцуулсан байна. Саналыг шийдвэрлүүлсэн байна.</p>	<p>БСАМДМЗООТБЗ-ийн ажлын алба М.Батбаатар Г.Шоовдор Д.Баасанжав Ж.Оюунчимэг</p>
--	--	---	--	---	--

	<p>1.3.2. Сургалт эрхлэгч ТББ-уудад хичээл заадаг багш нарын судалгааг шинэчлэн гаргаж, чадавхжуулах сургалт зохион байгуулж, сургалт эрхлэгч түншлэгч холбоодуудын сургалтын явцад чанарын болон санхүүгийн хяналт үзлэг шалгалт зохион байгуулж ажиллах.</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b> Сургалтын хичээл заах багш нар магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, 10-аас дээш жилийн багшлах туршлагатай байх.</p> <p><b>Тоо хэмжээ:</b> Жилд 50 багш нар, сургалт-1, хяналт, шалгалт- 2.</p>	<p>1. Багш нарыг чадавхижуулах сургалтыг I улиралд; 2.Хяналт шалгалтыг II, III улиралд хийнэ.</p>	<p>Багш нарын судалгаа гаргаж цаашид мэргэшүүлэх, сурган заах арга зүйн чадавхжуулах сургалтыг хийхээр төлөвлөж, бэлтгэл хангаж байна.</p> <p>Сургалтын явцад сэтгэл ханамжийн судалгаа авах замаар сургалтын чанарт хяналт тавьж байна.</p>	<p>Судалгааны үр дүнг зөвлөлд танилцуулсан байна.</p> <p>Багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлсэн байна.</p> <p>Сургалтын чанарт ахиц гарсан байна.</p>	<p>БСАМДМЗООБЗ-ийн Ажлын алба М.Батбаатар Г.Шоовдор ШУГИС-ийн БАС-ийн захирал Д.Нинжгарав</p>
<p><b>Хоёр. ИТА, ажиллах хүчний мэдээллийн сан, техник хэрэгслийн хангамжийн чиглэлээр:</b></p>					
<p>1. Мэргэжил дээшлүүлэх хамрагдсан мэргэшлийн зэрэгтэй талаарх нэгдсэн мэдээллийн санг хөтөлж, мэдээлэл лавлагаагаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үйлчлэх ажлыг "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-тай хамтран зохион байгуулах.</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b> Санг холбогдох мэдээллийг бүрэн хамруулсан байх. <b>Тоо хэмжээ:</b> Мэдээллийн сан -1, Мэргэжилтний тоо - 400.</p>	<p>Тухай бүр</p>	<p>Сургалт, шалгалтанд хамрагдсан мэргэжилтний материалаар нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулж, архивын нэгж болгон хадгалах ажиллагааг төрийн захиргааны байгууллагатай хамтран хийж байна.</p>	<p>Мэдээллийг санг тогтмол хөтөлж, баяжуулсан байна.</p> <p>Иргэд, аж ахуйн нэгж, холбогдох байгууллагууд мэдээллээр хангагдсан байна.</p>	<p>1."БХТ" ТӨААТҮГ 2.БСАМДМЗООБЗ-ийн ажлын алба Г.Шоовдор Д.Баасанжав Ж.Оюунчимэг Б.Болормаа</p>	

2.	<p>2.2. Барилгын салбарын ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг судалгааг гаргахад оролцож ажиллах.</p> <p>2.2.1. Барилгын салбарын ажиллах хүчний онлайн эрэлтийн судалгааг гаргахад харьяа аж ахуйн нэгжүүдийг оролцуулах ажлыг зохион байгуулах, болон үүнтэй хслбоотой хэлэлцүүлэг зохион байгуулахад оролцож ажиллах.</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Мэдээтэл үнэн бодит байх;</li> <li>- Аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулсан байх.</li> </ul> <p><b>Тоо хэмжээ:</b> Оролцсон аж ахуйн нэгжүүд-1200;</p> <p>Ажиллах хүчин ба мэргэжлийн эрэлтийн мэдээллийн сан-1.</p>	2020.04.15-ны дотор аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулсан байна.	Барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийн нэгдсэн судалгаанд 1200 ба түүнээс дээш аж ахуйн нэгжийг хамруулсан байна. Ажиллах хүчин, мэргэжилтэй ажилчдын талаар баримтлах бодлого, чиглэлийн суурь судалгаагаар болсон байна.	БСАМДМЗООБЗ-ийн ажлын алба А.Лхамсэржид Г.Шоовдор Д.Баасанжав Ж.Оюунчимэг Б.Болормаа
3.	<p>2.3. Сургалтын анги, танхим, техник хэрэгслээр бүрэн хангаж ажиллах.</p> <p>/Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дэхь хэсэгт заасан 3.2/</p> <p>2.3.1. Сургалтын анги танхим, техник хэрэгсэл, Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн ажлын албаны өрөөг шинэчлэх, түрээслүүлэх асуудлыг яам, "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ, МБНХ-той хамтран шийдвэрлэх./Гэрээний 2.3./</p> <p><b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Анги танхим, техник хэрэгслээр бүрэн хангагдаж сургалт явуулах боломжийг бүрдүүлсэн байх.</li> <li>- Энэ талаар суралцагчдыг сэтгэл ханамжийн баталгааг хангасан байх.</li> </ul> <p><b>Тоо хэмжээ:</b> Анги танхим, техник хэрэгслийн тоо.</p>	2020 оны II улиралд	2020 оны II улиралд энэ талаар дүгнэлт гаргасан байна. Суралцагчдын хэрэгцээнд нийцсэн анги, танхим, техник хэрэгслээр хангагдсан байна. Ажлын алба 2 – оос доошгүй өрөө тасалгаагаар болсон байна.	1.БСАМДМЗООБЗ, 2.Зөвлөлийн ажлын албаны М.Батбаатар Д.Баасанжав 3.БХТ
Гурав. Үйл ажиллагааны тайлан, хяналтын чиглэлээр:				

1.	<p>3.1. Холбогдох тайлан, мэдээг боловсруулж Зөвлөлд хургуулэх, сургалт, шалгалтын материалаар архивын нэгж үүсгэн хадгалах. /Гэрээний 3.7.13/</p> <p>3.1.1. Энэхүү төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийж, Зөвлөл, Зөвлөлийн Ажлын албаар батлуулж ажиллах, биелэлтийг жил бүр хагас, бүтэн жилээр гаргаж, яаманд ирүүлэх.  <b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b>  - Баримт бичиг боловсруулах шаардлага хангасан байх;  - Төлөвлөгөө биелэгдэхүйц, шалгуур үзүүлэлт, тоо хэмжээ хэмжигдэхүйц байх.  - Биелэлтийг яамны ТЗУГ-т хугацаанд нь ирүүлж байх.  <b>Тоо хэмжээ:</b>  Жил бүр биелэлт-2, төлөвлөгөө -1.</p> <p>3.1.2. Сургалт, шалгалтын материал болон гэрээ, төлөвлөгөө зэрэг холбогдох материалуудыг архивын нэгж болгон хадгалах.  <b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b>  - Архивын тухай хууль, холбогдох журмын дагуу  <b>Тоо хэмжээ:</b> Архивын нэгжийн тоо</p>	<p>Биелэлтийг II, IV улиралд, төлөвлөгөөг тухайн оны 2 дугаар сарын 15-ны дотор</p>	-	<p>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хэрэгжсэн байна.</p>	<p>БСАМДМЗООБЭЗ-ийн ажлын алба  А.Лхамсэржид  Д.Баасанжав  Н.Энхмэнд  Ж.Оюунчимэг</p>
2.	<p>3.2. Гэрээ болон энэхүү төлөвлөгөөний биелэлтэд яамны ХШУДАГ-аар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлтгэх.</p> <p>3.2.1. Гэрээ болон энэхүү төлөвлөгөөний биелэлтэд яамны ХШУДАГ-аар хяналт-шинжилгээ, үнэлгээг жилд нэг удаа хийлтгэх.  <b>Чанар, шалгуур үзүүлэлт:</b>  - Үнэлгээ, зөвлөмж гарсан байх.  - Зөвлөмжийг дагаж, мөрдсөн байх.  <b>Тоо хэмжээ:</b> Жил бүр ХШУ-1</p>	<p>Жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор</p>	-	<p>Баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу архивт хүлээлгэн өгсөн байна.</p>	<p>БСАМДМЗООБЭЗ-ийн ажлын алба</p> <p>1.БСАМДМЗООБЭЗ  2.Зөвлөлийн ажлын алба</p>

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР,  
БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗЭРЭГ ОЛГОХ  
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА